



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/376


Есөнбулаг

“Аймгийн ус-орчны эрүүл ахуйн
зөвлөл” байгуулах тухай


Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, эрүүл мэндийн сайдын 2021 оны А/349 дүгээр тушаал, Засгийн газрын 2017 оны 225 дугаар тогтоолоор баталсан “Орчны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн 7.2 дахь хэсэг, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2024 оны 17 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, ажиллах, суралцах нөхцөлийг сайжруулах зорилгоор “Ус, орчны эрүүл ахуйн аймгийн зөвлөл”-ийн удирдах бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, гүйцэтгэх багийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Ус, орчны эрүүл ахуйн талаарх орон нутгийн бодлого төлөвлөлтийг шинэчилж холбогдох олон улсын байгууллагатай хамтарч ажиллахыг Ус-орчны эрүүл ахуйн зөвлөлийн, ажлын хэсгийн ахлагч аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ш.Эрдэнэбат)-д даалгасугай.
3. Орчны эрүүл ахуйг сайжруулах, бохирдлыг бууруулан ажиллахад шаардагдах зардлыг жил бүрийн аймаг, сумын орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн төсөвт тусган ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Х.Баатарзориг), сумын Засаг дарга нарт тус тус даалгасугай.
4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2021 оны А/12 дугаар захирамж хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР



ЗӨВЛӨЛИЙН ГҮЙЦЭТГЭХ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- (Нийгмийн бодлогын хэлтсийн эрүүл мэнд, спорт, хөгжлийн бэрхшээлтэй иргэн хариуцсан мэргэжилтэн)
- (Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын байгаль орчин, геологи, уул уурхай аялал жуулчлалын бодлого хариуцсан хэлтсийн мэргэжилтэн)
- (Ус цаг уур орчны шинжилгээний төвийн цаг уур, орчны технологийн хэлтсийн дарга)
- (Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн)
- (Байгаль орчин аялал жуулчлалын газрын усны нөөц ашиглалт хамгаалалт хариуцсан мэргэжилтэн)
- (Орчны бохирдол хариуцсан мэргэжилтэн)
- (Аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн)
- (Усны сав газрын ахлах мэргэжилтэн)
- (Боловсрол, шинжлэх ухааны газрын эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн)
- (Ундарга-Алтай орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын инженер)
- (Есөнбулаг сумын эрүүл ахуй тохижилт үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн)
- (Эрүүл мэндийн газрын орчны эрүүл мэнд, тандалт хариуцсан мэргэжилтэн)
- (Эрүүл мэндийн газрын Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч)

__оОо__

Аймгийн Засаг даргын
20.14 оны 05 дугаар сарын 22-ны
өдрийн 376 дугаар захирамжийн
нэгдүгээр хавсралт

АЙМГИЙН УС-ОРЧНЫ ЭРҮҮЛ АХУЙН
ЗӨВЛӨЛИЙН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:
Нарийн бичгийн дарга:
Гишүүд:

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)
(Эрүүл мэндийн газрын дарга)
(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн
бодлогын хэлтсийн дарга)
(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн
бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн
дарга)
(Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)
(Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга)
(Боловсрол шинжлэх ухааны газрын дарга)
(Сумын Засаг даргын Тамгын газрын дарга нар)
(Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын
дарга)
(“Хүйсийн говь цэцэг нуурын сав газрын захиргаа”-ны
дарга)
(Ус цаг уур орчны шинжилгээний төвийн дарга)
(“Ундарга-Алтай” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот
үйлдвэрийн газрын дарга)

__оОо__